

## ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

### САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

ЭМЯ, Глобаль сангийн дэмжлэгтэй ДОХ, Сүрьеэгийн төслийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

Аудитын код: САГ-2026/86/НА-СТА-ТХН

Цахим хуудас: <a href="#">www.audit.mn</a> Улаанбаатар хот 2026 он	Санхүүгийн газрын захирал, тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг Утас:261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn Аудитын менежер: В.Эрдэнэцогт Утас:323266 Цахим хаяг: erdenetsogtv@audit.gov.mn Аудитор: Ж.Бямбацогт Утас: 323266 Цахим хаяг: bymbatsogtj@audit.gov.mn Гэрэлт хөхийн тэнцвэр аудит ХХК-ийн захирал: Д.Баатарсайхан Утас: 99099119 Цахим хаяг: gerelthuhaudit@gmail.com
--	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## АГУУЛГА

---

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ .....	4
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ .....	7
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА .....	13
4. АУДИТЫН ТАЙЛАН.....	17
4.1 Ерөнхий зүйл .....	17
4.2 Материаллаг байдал .....	18
4.3 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....	18
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт .....	18
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	18
4.5.1 Завсрын аудитын талаар .....	18
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	19
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ .....	19
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ .....	21

## Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
БЗДХ	Бэлгийн замаар дамжих халдварууд
ДОХ	Дархлалын олдмол хомсдол
ХДХВ	Хүний дархлал хомсдолын вирус
ХӨСҮТ	Халдварт өвчин судлалын үндэсний төв
ШШГЕГ	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ТББ	Төрийн бус байгууллага
ЭМЯ	Эрүүл мэндийн яам



## ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

Засгийн газрын IV байр, Бага тойруу 3,  
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160  
Утас: 26 04 37, Факс: (976-51) 26 42 30,  
Цахим шуудан: info@audit.gov.mn,  
Цахим хуудас: www.audit.mn

2026.03.16 № 06/637  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

ЭРҮҮЛ МЭНДИЙН ЯАМ, ГЛОБАЛЬ  
САНГИЙН ДЭМЖЛЭГТЭЙ ДОХ,  
СҮРЬЕЭГИЙН ТӨСЛИЙН ЗАХИРАЛ  
Б.ЦЭЦЭГСАЙХАН ТАНАА

### Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, 8.4 Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Эрүүл мэндийн яам, Глобалъ сангийн дэмжлэгтэй Дархлалын олдмол хомсдол, сүрьеэгийн төслийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

### Хязгаарлалттай дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлангийн аудитаар нийт 362,741.9 мянган төгрөгийн зөрчил илэрсэн нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд дангаараа болон нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй байна. Тухайлбал:

- Төслийн дансанд бүртгэлтэй 151,998.3 мянган төгрөгийн үнэтэй суудлын автомашиныг ашиглалтын түрээсийн гэрээгүй, шийдвэргүй, дээд шатны байгууллагад ашиглуулсан;
- Компьютер худалдан авах гэрээний 2.6-д заасан төлбөр төлөх нөхцөлийн зөрчиж, бараагаа хүлээн аваагүй байж 189,454.5 мянган төгрөгийн төлбөрийг бүрэн төлсөн;
- Төслийн санхүүжилтээр нийлүүлсэн 17,589.1 мянган төгрөгийн эм оношлуур, бараа материалыг дээд шатны төсөв захирагчийн тушаалгүй эрүүл мэндийн байгууллагуудад хуваарилж, зарлагдсан байна.

Дээрх зөрчлүүд нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1, Нягтлан бодох бүртгэлийн 5 дугаар зүйлийн 5.1.4, 13 дугаарын зүйлийн 13.1, 13.7, 20 дугаарын зүйлийн 20.1.4 дэх заалтуудтай нийцээгүй байна.

### **Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг**

Глобаль сангаас КОВИД-19 хариу арга хэмжээний механизмын ("С19RM") төслийн төсөвт өртгийн 31.3 хувийг эзэлдэг Халдварт өвчний тандалтын цахим систем хөгжүүлэх төслийн ажлын явц, гүйцэтгэл хангалтгүй, хугацаандаа хэрэгжих боломжгүй гэж дүгнэж, 2,862,121.7 мянган төгрөгийн хөрөнгө оруулалтыг бүрэн зогсоох шийдвэр бүхий албан захидлыг 2025 оны 03 дугаар сард төсөл хэрэгжүүлэх нэгжид ирүүлсэн байна. Иймээс Халдварт өвчний тандалтын цахим систем хөгжүүлэх төслийг зогсоосон байна.

### **Аудитын гол асуудал**

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Төслийн хүрээнд тайлант оны эрүүл мэндийн бүтээгдэхүүний гадаад ханган нийлүүлэлтийг 12,211,495.7 мянган төгрөгөөр төлөвлөж, гүйцэтгэл 11,779,893.7 мянган төгрөг байна. Энэ нь нийт худалдан авалтын 97.0 хувийг эзэлж байна.

### **Бусад асуудал**

Глобал сангийн санхүүжилттэй төсөл нь тайлант онд нийт 408 үйл ажиллагаа хийхээр төлөвлөж, сургалт, уулзалт, судалгаа, үнэлгээ гэх мэт ажлуудыг түр зогсоох зөвлөмжийг Глобал сангийн Женев дэх төвөөс өгснөөс шалтгаалан 41 ажил хийгдээгүй, хэрэгжилт 88.0 хувь байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Дансны нэр, төрөл	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>6,682,737,777.76</b>	<b>21,866,346,692.13</b>
<b>31</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	<b>4,515,183,217.33</b>	<b>11,583,252,148.18</b>
31200	Банкинд байгаа бэлэн мөнгө	4,515,183,217.33	11,583,252,148.18
31220	Гадаад валют	4,515,183,217.33	11,583,252,148.18
31223	Арилжааны банк дахь харилцах	4,515,183,217.33	11,583,252,148.18
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	<b>477,189,028.65</b>	<b>8,277,899,618.54</b>
33500	Бусад авлага	477,189,028.65	8,277,899,618.54
33510	Байгууллагаас авах авлага	477,189,028.65	8,277,899,618.54
<b>34</b>	<b>УРЬДЧИЛГАА</b>	<b>956,508,526.18</b>	<b>1,357,138,982.45</b>
34600	Урьдчилж гарсан зардал	952,808,526.18	1,357,138,982.45
34710	Урьдчилгаа тооцоо	3,700,000.00	-
34714	Томилолтын урьдчилгаа	3,700,000.00	-
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	<b>733,857,005.60</b>	<b>648,055,942.96</b>
35100	Түүхий эд материал	717,388,505.60	178,624,782.54
35130	Эм боох материал	717,388,505.60	178,624,782.54
35400	Хангамжийн материал	16,468,500.00	469,431,160.42
35470	Бусад хангамжийн материал	16,468,500.00	469,431,160.42
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>504,310,276.57</b>	<b>441,165,292.97</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	<b>504,310,276.57</b>	<b>441,165,292.97</b>
39200	Биет хөрөнгө	504,310,276.57	441,165,292.97

ЭМЯ, Глобаль сангийн дэмжлэгтэй ДОХ, Сүрьеэгийн төслийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

39203	Авто-тээврийн хэрэгсэл	313,716,525.72	313,716,525.72
39204	Хуримтлагдсан элэгдэл	(127,326,902.32)	(146,917,115.20)
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	587,679,457.75	600,536,084.93
39206	Хуримтлагдсан элэгдэл	(290,905,648.46)	(347,325,546.42)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	46,017,831.40	49,390,285.94
39208	Хуримтлагдсан элэгдэл	(24,870,987.52)	(28,234,942.00)
39301	Програм хангамж	20,320,000.00	20,320,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(20,320,000.00)	(20,320,000.00)
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН 3=1+2</b>	<b>7,187,048,054.33</b>	<b>22,307,511,985.10</b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>4,818,577,078.90</b>	<b>8,751,942,742.33</b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>4,818,577,078.90</b>	<b>8,751,942,742.33</b>
41300	Өглөг	327,342,424.33	25,221,186.36
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	-	16,066,297.50
41360	Бусад өглөг	327,342,424.33	9,154,888.86
41361	Байгууллагад төлөх өглөг	327,342,424.33	9,154,888.86
41400	Урьдчилж орсон орлого	4,491,234,654.57	8,726,721,555.97
41440	Бусад урьдчилж орсон орлого	4,491,234,654.57	8,726,721,555.97
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>2,368,470,975.43</b>	<b>13,555,569,242.77</b>
51	Засгийн газрын хувь оролцоо	2,368,470,975.43	13,555,569,242.77
51200	Хуримтлагдсан үр дүн	2,368,470,975.43	13,555,569,242.77
51210	Өмнөх үеийн үр дүн	4,809,661,409.91	2,368,470,975.43
51220	Тайлант үеийн үр дүн	(2,441,190,434.48)	11,187,098,267.34
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН 6=4+5</b>	<b>7,187,048,054.33</b>	<b>22,307,511,985.10</b>

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Дансны нэр, төрөл	Өмнөх он	Тайлант он
<b>I</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН</b>	<b>16,105,184,069.19</b>	<b>29,301,328,928.83</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>16,105,184,069.19</b>	<b>29,301,328,928.83</b>
120	Нийтлэг татварын бус орлого	9,294,235,531.86	14,120,654,137.92
1201	Хүүгийн орлого	14,455,778.41	9,397,809.29
120002	Бусад хүүгийн орлого	14,455,778.41	9,397,809.29
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	8,344,916,759.13	-
1200044	Гадаадын эх үүсвэрээс санхүүжих	8,344,916,759.13	-
120009	Бусад орлого	-	13,463,680,457.89
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	934,862,994.32	647,575,870.74
122	Тусламжийн орлого	6,810,948,537.33	15,180,674,790.91
122002	Хандив тусламж /гадаад/	6,810,948,537.33	15,180,674,790.91
<b>II</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>18,502,217,957.83</b>	<b>17,977,302,584.29</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>18,502,217,957.83</b>	<b>17,977,302,584.29</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>17,587,479,987.44</b>	<b>17,336,969,267.39</b>
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,138,594,898.93	2,589,106,701.27
210101	Үндсэн цалин	2,136,794,898.93	2,569,000,339.27
210104	Урамшуулал	1,800,000.00	20,106,362.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	172,676,127.57	246,827,897.40
210201	Тэтгэврийн даатгалын зардал	172,676,127.57	181,437,944.11
210202	Тэтгэмжийн даатгалын зардал	-	21,228,274.53
210203	ҮОМШӨ-ний даатгалын зардал	-	5,065,167.59
210204	Ажилгүйдлийн даатгалын зардал	-	758,051.00
210205	Эрүүл мэндийн даатгалын зардал	-	38,338,460.17
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	205,595,895.00	238,060,086.10
210301	Гэрэл, цахилгаан	2,328,895.00	2,927,993.00
210304	Байрны түрээс	203,267,000.00	235,132,093.10
2104	Хангамж, бараа материалын зардал	111,964,731.33	35,570,538.30
210401	Бичиг хэрэг	3,916,681.91	3,881,617.88
210402	Тээвэр, шатахуун	2,625,000.00	2,200,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	9,014,281.00	9,389,420.42
210404	Ном, хэвлэл	81,539,500.00	20,099,500.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	14,869,268.42	-
2105	Нормативт зардал	9,975,723,815.75	6,851,809,290.52
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	9,975,723,815.75	6,851,809,290.52

ЭМЯ, Глобаль сангийн дэмжлэгтэй ДОХ, Сүрьеэгийн төслийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

2106	Эд хогшил, урсгал засварын зардал	362,585,744.50	-
210604	Урсгал засвар	362,585,744.50	-
2107	Томилолт, зочны зардал	57,047,300.00	15,640,000.00
210702	Дотоод албан томилолт	57,047,300.00	15,640,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	594,059,780.23	780,953,513.24
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	501,966,850.23	664,243,901.24
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	88,000,000.00	114,000,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	4,092,930.00	2,709,612.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	3,969,231,694.13	6,579,001,240.56
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	2,641,735,204.79	5,125,585,663.02
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,187,526,543.94	1,374,041,512.22
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	139,969,945.40	79,374,065.32
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>914,737,970.39</b>	<b>640,333,316.90</b>
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	914,737,970.39	640,333,316.90
21311	Засгийн газрын дотоод шилжүүлэг	914,737,970.39	640,333,316.90
213101	Бусад засгийн газрын дотоод шилжүүлэг	914,737,970.39	640,333,316.90
<b>III</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)</b>	<b>-2,397,033,888.64</b>	<b>11,324,026,344.54</b>
<b>IV</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН</b>	<b>9,970,645.96</b>	<b>43,599,806.51</b>
145001	Гадаад валютын ханшийн зөрүүний олз	9,970,645.96	43,599,806.51
<b>V</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>54,127,191.80</b>	<b>180,527,883.71</b>
225004	Гадаад валютын ханшийн зөрүүний гарз	34,002,167.87	173,285,329.87
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	20,125,023.93	7,242,553.84
<b>VII</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (VII)=(IV)-(V)</b>	<b>(44,156,545.84)</b>	<b>(136,928,077.20)</b>

### 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Дансны нэр, төрөл	Өмнөх он	Тайлант он
<b>I</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН</b>	<b>12,369,274,818.01</b>	<b>17,772,736,472.54</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>12,369,274,818.01</b>	<b>17,772,736,472.54</b>
120	Нийтлэг татварын бус орлого	12,369,274,818.01	17,772,736,472.54
1201	Хүүгийн орлого	36,396,869.38	75,628,964.54
120002	Бусад хүүгийн орлого	36,396,869.38	75,628,964.54
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	12,332,877,948.63	-
1200044	Гадаадын эх үүсвэрээс санхүүжих	12,332,877,948.63	-

ЭМЯ, Глобаль сангийн дэмжлэгтэй ДОХ, Сүрьеэгийн төслийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

120009	Бусад орлого	-	17,697,107,508.00
<b>II</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>8,331,498,469.34</b>	<b>10,631,667,518.82</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>8,331,498,469.34</b>	<b>10,631,667,518.82</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>8,331,498,469.34</b>	<b>10,631,123,233.82</b>
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,110,030,945.26	2,775,448,739.39
210101	Үндсэн цалин	2,108,005,945.26	2,744,406,653.39
210104	Урамшуулал	2,025,000.00	31,042,086.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	206,062,077.55	270,799,230.49
210201	Тэтгэврийн даатгалын зардал	206,062,072.67	195,875,286.98
210202	Тэтгэмжийн даатгалын зардал	4.88	25,103,668.89
210203	ҮОМШӨ-ний даатгалын зардал	-	5,412,242.82
210204	Ажилгүйдлийн даатгалын зардал	-	1,909,275.20
210205	Эрүүл мэндийн даатгалын зардал	-	42,498,756.60
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	205,334,095.00	237,460,686.20
210301	Гэрэл, цахилгаан	2,328,895.00	2,927,993.00
210304	Байрны түрээс	203,005,200.00	234,532,693.20
2104	Хангамж, бараа материалын зардал	118,197,453.82	36,078,720.12
210401	Бичиг хэрэг	3,916,681.91	3,929,799.70
210402	Тээвэр, шатахуун	2,625,000.00	2,200,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	9,371,371.91	9,389,420.42
210404	Ном, хэвлэл	89,228,000.00	20,559,500.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	13,056,400.00	-
2105	Нормативт зардал	37,013,364.00	9,179,060.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	37,013,364.00	9,179,060.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	362,975,644.50	-
210602	Тавилга	389,900.00	-
210604	Урсгал засвар	362,585,744.50	-
2107	Томилолт, зочны зардал	55,669,500.00	11,940,000.00
210702	Дотоод албан томилолт	55,669,500.00	11,940,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	617,610,595.47	132,432,202.38
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	511,773,219.95	28,153,500.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	101,000,000.00	101,000,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	4,092,930.00	2,709,612.00

ЭМЯ, Глобалъ сангийн дэмжлэгтэй ДОХ, Сүрьеэгийн төслийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	744,445.52	569,090.38
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	4,618,604,793.74	7,157,784,595.24
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	3,294,616,781.97	5,998,282,175.10
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,323,988,011.77	1,159,502,420.14
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	-	<b>544,285.00</b>
2132	Бусад урсгал шилжүүлэг	-	544,285.00
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	-	544,285.00
<b>III</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)</b>	<b>4,037,776,348.67</b>	<b>7,141,068,953.72</b>
14	Бусад эх үүсвэр	25,706,796.30	97,200,985.93
145001	Гадаад валютын ханшийн зөрүүний олз	25,706,796.30	97,200,985.93
<b>25</b>	<b>САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ</b>	<b>35,575,862.65</b>	<b>170,201,008.80</b>
250001	Гадаад валютын ханшийн зөрүүний гарз	35,575,862.65	170,201,008.80
<b>VII</b>	<b>САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН</b>	<b>(9,869,066.35)</b>	<b>(73,000,022.87)</b>
<b>VIII</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)</b>	<b>4,027,907,282.32</b>	<b>7,068,068,930.85</b>
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	487,275,935.01	4,515,183,217.33
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	4,515,183,217.33	11,583,252,148.18

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	Засгийн газрын хувь оролцооны дүн
1	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл			4,649,622,464.57	4,649,622,464.57
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл			4,649,622,464.57	4,649,622,464.57
9	Тайлант үеийн үр дүн			(2,441,190,434.48)	(2,441,190,434.48)
10	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл			2,368,470,975.43	2,368,470,975.43
11	2025 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл			2,368,470,975.43	2,368,470,975.43

12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				-
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл			2,368,470,975.43	2,368,470,975.43
19	Тайлант үеийн үр дүн			11,187,098,267.34	11,187,098,267.34
20	2025 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл			13,555,569,242.77	13,555,569,242.77

### 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

#### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

ЭМЯ, Глобаль сангийн дэмжлэгтэй ДОХ, сүрьеэгийн төсөл нь 2003 оноос хэрэгжиж эхэлсэн ба сүрьеэтэй тэмцэх, сэргийлэх чиглэлээр 9 дэх удаагийн төслийг хэрэгжүүлж байна.

Глобаль сангийн санхүүжилтээр хэрэгжиж байгаа хөтөлбөрийн зорилго нь ХДХВ-ийн тархалт, ДОХ-той холбоотой нас баралтыг бууруулах, хүн төвтэй эрүүл мэндийн цогц үйлчилгээ үзүүлж, сүрьеэгийн тохиолдол илрэлтийг нэмэгдүүлж оношилгоо, эмчилгээний шинэлэг аргуудыг нэвтрүүлж, олон талт хамтын ажиллагааг өргөжүүлэн бэхжүүлэхэд чиглэгдэж байна.

*Хөтөлбөрийн зорилт:*

- 2026 он гэхэд ХДХВ-ийн халдвартай хүмүүсийн 63-аас доошгүй хувийг Ретровирусын эсрэг эмчилгээнд хамруулах;
- Ретровирусын эсрэг эмчилгээнд хамрагдсан хүмүүсийн дунд вирусийн ачааллыг 95.0 хувьд байлгах;

Тус төслийн үндсэн хүлээн авагч байгууллага нь Эрүүл мэндийн яам бөгөөд дараах салбар хүлээн авагч байгууллагуудаар дамжуулан хэрэгжүүлж байна. Үүнд:

- Халдварт өвчин судлалын үндэсний төв
- Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар
- Эрүүл мэндийн хөгжлийн төв
- Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төв
- ШШГЕГ-ын харьяа 429 дүгээр хаалттай хорих анги, төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, 6 төрийн бус байгууллагыг хамруулан хэрэгжүүлж байна.

Монгол Улсаас Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын Засгийн газрат төлөх 29.0 сая еврогийн өрийг “Өр хөрвүүлэх хэлэлцээр”-ээр Глобаль сангаар дамжуулан Монгол Улсын эрүүл мэндийн салбарт буцалтгүй тусламж хэлбэрээр 2025-2030 оны хооронд олгох болсон байна. “Өр хөрвүүлэх хэлэлцээр”-ээр уг хөрөнгийг тайлант оноос эхлэн Глобаль сангийн одоо хэрэгжиж байгаа GS7 төсөлд нэмэлт санхүүжилт хэлбэрээр 2025-2026 онд нэмж олгохоор шийвэрлэсэн байна

#### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тус төсөл нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Эрүүл мэндийн тухай хууль болон бусад хууль тогтоомжид нийцүүлэн ХДХВ-ийн тархалт,

ДОХ-той холбоотой нас баралтыг бууруулах, хүн төвтэй эрүүл мэндийн цогц үйлчилгээ үзүүлэх зэрэг үндсэн чиг үүргээ хэрэгжүүлж байна.

Тайлант хугацаанд төслийн нэгжийн үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрдөх хууль, тогтоомж, бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй гэж үнэлэв.

ЭМЯ-ны Хяналт, шинжилгээ, үнэлгээ дотоод аудитыг газраас тус байгууллагын 2025 оны үйл ажиллагаанд хяналт шалгалт хийгээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

ЭМЯ, Глобаль сангийн дэмжлэгтэй ДОХ, Сүрьеэгийн төслийн 2025 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

ЭМЯ, Глобаль сангийн дэмжлэгтэй ДОХ, Сүрьеэгийн төслийн 2025 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2025 оны А/03 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам”-ын дагуу бэлтгэсэн байна.

ЭМЯ, Глобаль сангийн дэмжлэгтэй ДОХ, Сүрьеэгийн төсөл нь санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаандаа Глобаль сангийн “Буцалтгүй тусламжийн төсөв боловсруулах үйл ажиллагааны журам”-ыг мөрдөн ажилладаг бөгөөд тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 15,120.5 сая төгрөгөөр буюу 220 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	4,515,183.2	11,583,252.1	7,068,068.9
Авлага	477,189.0	8,277,899.6	7,800,710.6
Урьдчилгаа	956,508.5	1,357,139.0	400,630.5
Бараа материал	733,857.0	648,055.9	(85,801.1)
Үндсэн хөрөнгө	504,310.3	441,165.3	(63,145.0)
<b>Нийт хөрөнгө</b>	<b>7,187,048.1</b>	<b>22,307,512.0</b>	<b>15,120,463.9</b>
Өр төлбөр	4,818,577.1	8,751,942.7	3,933,365.7

Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	2,368,471.0	13,555,569.2	11,187,098.3
<b>Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн</b>	<b>7,187,048.1</b>	<b>22,307,512.0</b>	<b>15,120,463.9</b>

Дээрх хүснэгтээс харахад, нөлөө бүхий өөрчлөлт гарсан мөнгөн хөрөнгө, авлага, өр төлбөр, засгийн газрын хувь оролцоо данстууд байна. Үүнд:

- Мөнгөн хөрөнгийн оны эцсийн үлдэгдэл 7,068,068.9 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь тайлант онд төслийн хүрээнд шинээр Өр хөрвүүлэх хөтөлбөрийн нэмэлт санхүүжилтийн сонгон шалгаруулалт хийгдээгүй үлдэгдэлтэй байгаа нөлөөлсөн байна.
- Авлага дансны оны эцсийн үлдэгдэл 8,277,899.6 мянган төгрөг болж өмнөх оноос 7,800,710.6 мянган төгрөгөөр өссөн нь 8,265,371.8 мянган төгрөгийн өртөг бүхий бараа, ханган нийлүүлэгч байгууллагаас гаалиар орж ирээгүй байгаа нь голлон нөлөөлсөн байна.
- Бараа материалын дансны үлдэгдэл 648,055.9 мянган төгрөг болж 85,801.1 мянган төгрөгөөр буурсан нь төслийн санхүүжилтээр тайланд онд нийлүүлэгдсэн 3,432,866.8 мянган төгрөгийн эм оношлуур, бараа материалыг орлогод авч, 3,971,630.5 мянган төгрөгийн бараа материалыг эрүүл мэндийн байгууллагуудад хуваарилж, олгосон, мөн 1,054,356.4 мянган төгрөгийн материал орлого авч 601,393.1 мянган төгрөгийн материал зарцуулсан нь нөлөөлсөн байна,
- Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл 441,165.3 мянган төгрөг болж 63,145.0 мянган төгрөгөөр буурсан нь тайлант онд 79,374.0 мянган төгрөгийн элэгдэл байгуулсан нь голлон нөлөөлсөн байна.
- Өр төлбөрийн дансны үлдэгдэл 8,751,942.7 мянган төгрөг болж 3,933,365.7 мянган төгрөгөөр өссөн нь төсөл хэрэгжиж эхлэх хугацаа хойшилсноос шалтгаалан төслийн салбар хүлээн авагч байгууллагуудад хуваарилагдаагүй 4,235,486.9 мянган төгрөг, татварын байгууллагад төлөх өр төлбөр 18,168.9 мянган төгрөгөөр тус тус өсөж он дамжсан өглөгийн үлдэгдэлийг 320,295.0 мянган төгрөгөөр барагдуулсан нь голлон нөлөөлсөн байна.
- Цэвэр хөрөнгө/ өмчийн дансны үлдэгдэл өмнөх оны үлдэгдлээс 11,187,098.3 мянган төгрөгөөр өссөн нь өмнөх оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн үйл ажиллагааны үр дүнгээр Засгийн газрын хувь оролцоог нэмэгдүүлснээс шалтгаалсан байна.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.5.1 Төслийн хугацаа, санхүүжилт

Тус төсөл нь 2024 оны 1 дүгээр сарын 01-ээс 2026 оны 12 дугаар сарын 31-ийг хүртэл буюу 3 жилийн хугацаанд хэрэгжих бөгөөд нийт санхүүжилт нь 28,946,878.00 ам.доллар байна. Үүнд:

- 2024-2025 онд хэрэгжих C19RM буюу Коронавируст халдварын хариу арга хэмжээний санхүүжилт 2,966,841.00 ам.доллар;
- 2024-2026 онд хэрэгжих үндсэн төсөл 14,094,536.00 ам.доллар;
- 2025-2026 онд хэрэгжих “Өр хөрвүүлэх хөтөлбөр”-ийн хүрээнд хэрэгжих төслийн санхүүжилт 11,885,500.00 ам.доллар байна.

“Өр хөрвүүлэх хөтөлбөр” тайлант оноос хэрэгжиж эхэлсэн байна.

2024-2026 онд хэрэгжих төслийн нийт төсөв

/мянган төгрөг/

Он	GC-7						Нийт төсөв (USD)	Нийт төсөв (мянган төгрөг)
	Үндсэн төсөлт Өр хөрвүүлэх төсөл (USD)	Ханш	Үндсэн төсөл Өр хөрвүүлэх төсөл (мянган төгрөг)	C19RM Ковид-19 (USD)	Ханш	C19RM Ковид -19 (мянган төгрөг)		
2024	3,067,212.00	3,412.5	10,528,358.5	2,755,041.00	3,087.5	8,506,216.6	5,822,253.00	19,034,575.2
2025	10,374,908.00	3,412.5	35,612,390.5	211.800.00	3,087.5	653,934.6	10,586,708.00	36,266,325.4
2026	10,751,543.00	3,412.5	36,905,208.9				10,751,543.00	36,905,208.9
<b>Дүн</b>	<b>24,193,663.00</b>	<b>3,412.5</b>	<b>83,045,957.9</b>	<b>2,966,841.00</b>	<b>3,087.5</b>	<b>9,160,151.3</b>	<b>27,160,504.00</b>	<b>92,206,109.2</b>

Тайлбар: ам.долларыг төгрөгт хөрвүүлэх ханшийг тухайн өдрийн Монгол банкны ханшаар тооцож. Анх төсөл авахдаа Глобаль сан тогтсон ханшаар хүлээн авдаг байна.

### 3.5.2 Орлогын гүйцэтгэл

ЭМЯ, Глобаль сангийн дэмжлэгтэй ДОХ, сүрьеэгийн төслийн үйл ажиллагаанд зориулж 17,697,107.5 мянган төгрөгийн санхүүжилт, 75,628.9 мянган төгрөгийн хүү, торгуулийн хөнгөлөлтийн орлого, нийт 17,772,736.4 мянган төгрөгийн орлого төвлөрсөн байна. Глобаль сангийн төв нь шаардлагатай бараа материал, үндсэн хөрөнгийг захиалгын дагуу ирүүлсэн, түүний тээвэр, засвар үйлчилгээний зардал гуравдагч этгээдэд шууд төлөгдсөн зөвлөх үйлчилгээ, сургалт зэрэг зардлыг төлөвлөсөн байна.

### 3.5.3 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тайлант хугацаанд нийт 408 үйл ажиллагаа төлөвлөгдсөнөөс 41 ажил хийгдээгүй, хэрэгжилт 88 хувь байна.

Төслийн нэр	Батлагдсан төсөл	Төсөл хэрэгжилт	Зөрүү
ЭМЯ, Глобаль сангийн дэмжлэгтэй ДОХ, сүрьеэгийн төсөл: MNG-C-MOH	36,266,325,073	17,697,107,567	18,569,217,506

Төслийн санхүүжилт 17,697,107.5 мянган төгрөг буюу 48.8 хувийн гүйцэтгэлтэй байна. Үүнд:

- Глобаль сангаас олгох санхүүжилтийн амлалт буурсантай холбоотой 2025 оны 4 дүгээр сараас 10 дугаар сарын хооронд үйл ажиллагааг ач холбогдлоор нь дахин эрэмбэлж сургалт, уулзалт, судалгаа, үнэлгээ гэх мэт ажлуудыг түр зогсоосон;
- “Өр хөрвүүлэх хөтөлбөр”-ийн хүрээнд төлөвлөгдсөн томоохон дүнтэй Нийгмийн эрүүл мэндийн ажилтныг бэлтгэх сургалтууд, нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний тухай хуулийг хэрэгжүүлэх нэгдсэн ажлын төлөвлөгөө батлагдаагүйтэй холбоотой хойшилсон;
- “Өр хөрвүүлэх хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх, эрүүл мэндэд нэмэлт санхүүжилтийн хүрээнд ажиллах ТББ-ыг сонгон шалгаруулах тендерийн үйл ажиллагаа удааширсан, тендерээр сонгогдсон 4 багцаас 3-ыг нь Глобаль сан зөвшөөрөөгүйтэй холбоотой гэрээг цуцлаж, тендерийг дахин зохион байгуулахаар болсон;
- КОВИД-19 төслийн хүрээнд төлөвлөгдсөн “Тандалтын нэгдсэн програм хангамж” хөгжүүлэх ажил цуцлагдсан зэрэг нь нөлөөлсөн байна.

### 3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

#### Олон улсын ханган нийлүүлэлт, худалдан авалтын үйл ажиллагаа:

Wambo.org, UNWebBuy, iPlus, GDF зэрэг олон улсын ханган нийлүүлэгчдийн цахим системийг ашиглан ханган нийлүүлэлтийн хүсэлтүүдийг цаг тухайд нь илгээж, холбогдох баталгаажуулалт, зохицуулалт, хяналтын арга хэмжээг хэрэгжүүлсэн байна.

Ханган нийлүүлэлтийн цахим сүлжээгээр дамжуулан MNG-C-MOH төслийн 2025 онд худалдан авах 3,557,557 ам.долларын эм, хэрэгсэл, тоног төхөөрөмж худалдан авч, нийлүүлэхээр төлөвлөж, гүйцэтгэлээр Глобаль сангаас захиалгын төлбөрүүд бүрэн төлөгдөж, санхүүжилтийн хэрэгжилт 100 хувь байна.

Тайлант онд нийт 4,301,099.8 мянган төгрөгийн өртөг бүхий 100 нэр төрлийн эм, эмнэлгийн хэрэгсэл, тоног төхөөрөмжийн гаалийн бүрдүүлэлт, татвараас чөлөөлөх үйл явцыг зохион байгуулж, салбар хүлээн авагчдад хуваарилах тушаалын төслийг ЭМЯ-д хүргүүлсэн байна.

Нийт барааны 87.0 хувь буюу 3,751,012.3 мянган төгрөгийн өртөг бүхий барааны хуваарилалтын тушаал батлагдан эцсийн хэрэглэгчдэд стандартын дагуу хүргэгдэх ажлыг зохион байгуулсан, үлдэгдэл 532,364.4 мянган төгрөгийн бараа хуваарилах ЭМЯ-ны тушаал гараагүй хүлээгдэж байна.

PQR системд сүрьеэгийн эм, урвалж оношлуурын 8 удаагийн олон улсын худалдан авалтын үнэ, чанарын мэдээллийг бүрэн оруулсан. Глобаль сангийн үнийн хяналт, тайлагналын ил тод байдлын үнэлгээг ханган ажилласан.

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу ЭМЯ, Глобаль сангийн дэмжлэгтэй ДОХ, сүрьеэгийн төслийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийсэн байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах, шатахууны тооцоо, анхан шатны баримт, зардлын бүртгэлтэй холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Гэрэлт хөхийн тэнцвэр аудит ХХК-ийн аудитор Ш.Нарантуяа, аудиторын туслах Ц.Аюушжав нар гүйцэтгэж, анхан шатны хяналтыг Д.Хишгээ, Санхүүгийн аудитын газрын аудитор Ж.Бямбацогт, аудитын менежер В.Эрдэнэцогт, газрын захирал, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг нар дараагийн шатны хяналтыг тус тус хэрэгжүүлсэн.

ЭМЯ, Глобаль сангийн дэмжлэгтэй ДОХ, сүрьеэгийн төслийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Үндэсний аудитын газарт 2026 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн 26/20 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

## 4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2024 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2024 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 18,502,217.9 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 185,022.2 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

## 4.3 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

### 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

ЭМЯ, Глобаль сангийн дэмжлэгтэй ДОХ, сүрьеэгийн төслийн шилэн дансны мэдээллийг шалгахад байгууллага шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлэн ажилласан байна.

### 4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

## 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

### 4.5.1 Завсрын аудитын талаар

Шалгагдагч байгууллагын 2025 оны санхүүгийн тайланд завсрын аудит хийгээгүй.

### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны аудитаар илэрсэн зөрчилд өгсөн 4,243,973.9 мянган төгрөгийн албан шаардлагыг барагдуулан, 13,783.5 мянган төгрөгийн зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлсэн байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Албан шаардлага	1	4,243,973.9	1	4,243,973.9	100

Зөвлөмж	2	13,783.5	2	13,783.5	100
<b>Нийт дүн</b>	<b>3</b>	<b>4,243,973.9</b>	<b>3</b>	<b>4,243,973.9</b>	<b>100</b>

#### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

ЭМЯ, Глобаль сангийн дэмжлэгтэй ДОХ, сүрьеэгийн төслөөс ХӨСҮТ-д ажиллагсдад төслөөс олгож буй цалин, НДШ-ийн тооцоог анхаарч үзэх шардлагатай байна.

### 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 362,741.9 мянган төгрөгийн зөрчил<sup>1</sup> илэрснээс, 151,998.3 мянган төгрөгийн 1 албан шаардлага хүргүүлж, 210,743.6 мянган төгрөгийн зөвлөмж өгсөн.

Нийт илрүүлсэн зөрчлөөс 362,741.9 мянган төгрөгийн зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс 177,719.7 мянган төгрөгөөр давсан тул “Хязгаарлалттай” дүгнэлт өглөө.

#### 5.1 Албан шаардлага

1. Үндсэн хөрөнгийн дансанд 151,998.3 мянган төгрөгийн өртөгтэй Ланд-300 суудлын автомашиныг дээд байгууллагын шийдвэргүй, ашиглалтын түрээсийн гэрээгүй, үнэ төлбөргүй Эрүүл мэндийн яаманд ашиглуулж байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1-т "Төрийн өмчийн эд хөрөнгийг эрх бүхий байгууллагын шийдвэрээр төр, хувийн хэвшлийн түншлэлийн болон түрээсийн гэрээгээр, мөн хуулиар зөвшөөрсөн бол үнэ төлбөргүйгээр бусдад эзэмшүүлж, ашиглуулж болно" гэж заасантай нийцээгүй.

Шийдвэрлэсэн: Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль болон бусад холбогдох хуулийг мөрдөж, дээд шатны байгууллагаас зөвшөөрөл аваагүй, гэрээгүй ашиглуулсан зөрчлийг таслан зогсоож, давтан гаргахгүй байх албан шаардлага өгөх

#### 5.1 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. *Зардлын данстай холбоотой асуудал:*

Илрүүлэлт: Бодь электроникс компанитай байгуулсан 2024 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн Г/85 дугаар Комьпютер худалдан авах гэрээний 2.6-д заасан төлбөр төлөх нөхцлийг зөрчиж, 189,454.5 мянган төгрөгийн төлбөрийг бүрэн төлж, 3 сарын дараа хөрөнгийг хүлээн авсан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т "үнэн зөв байх", Ерөнхий гэрээний дагуу худалдан авах гэрээний 4.2-т "Гүйцэтгэгч нь гэрээний үүргээ бүрэн биелүүлсний дараагаар төлбөр хийхийг хүссэн хүсэлтийг төлбөрийн нэхэмжлэх болон 2.6 дахь хэсэгт заасан баримт бичгийн хамт захиалагчид хүргүүлнэ" гэсэн заалтыг хэрэгжүүлээгүй.

<sup>1</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Өгсөн зөвлөмж: Гэрээний хэрэгжилтэд тавих хяналтыг сайжруулж, бэлтгэн нийлүүлэгчтэй тооцоо нийлж баталгаажуулан санхүүжилт олгож байх

*Бараа материалын данстай холбоотой асуудал:*

Илрүүлэлт: Төслийн 17,589.1 мянган төгрөгийн санхүүжилтээр нийлүүлэгдсэн эм оношлуур, бараа материалыг эрүүл мэндийн байгууллагуудад хувиарлаж, зарлагдсаны дараа ЭМЯ-ний төрийн нарийн бичгийн даргын бараа материал хувиарласан тушаал шийдвэрийг нөхөн гаргуулж, баримтыг бүрдүүлж байгаа нь төслийн хөрөнгө үр ашиггүй зарцуулагдах эрсдэлтэй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т "үнэн зөв байх", 13.1-т "санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", 13.7-т "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", 20.1.4-т "хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх" гэж тус тус заасантай нийцээгүй.

Өгсөн зөвлөмж: Төсвийн шууд захирагч нь хөтөлбөр, арга хэмжээний хэрэгжилтийг үнэн зөв тайлагнах, дотоод хяналтыг сайжруулах, төслийн хүрэх үр дүнг хангаж ажиллах.

*3. Зардлын бүртгэлтэй холбоотой асуудал:*

Илрүүлэлт: Албан томилолтын хуудсанд томилолтоор ирсэн, буцсан огноо тэмдэглээгүй, 3,700.0 мянган төгрөгийн томилолтын зардлын анхан шатны баримтын бүрдэл хангалтгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т "үнэн зөв байх", 13 дугаар зүйлийн 13.1-т "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно" 13.7-т "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэж заасантай тус тус нийцээгүй.

Өгсөн зөвлөмж: Баримтын бүрдэл дутуу томилолтын тооцоог хаасан зөрчлийг таслан зогсоож, цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

№	Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс								Хууль, хяналтын байгууллагад шилжүүлэх асуудал	
				Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага			
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Албан томилолтын хуудсанд томилолтоор ирсэн, буцсан огноо тэмдэглээгүй, баталгаажуугүй, анхан шатны баримтын бүрдэл хангалтгүй байна.	1	3,700.0					1	3,700.0				
2	Үндсэн хөрөнгийн дансанд бүртгэлтэй Ланд-300 суудлын автомашиныг дээд байгууллагын шийдвэргүй, ашиглалтын түрээсийн гэрээгүй, үнэ төлбөргүй Эрүүл мэндийн яаманд ашиглуулж байна.	1	151,998.3			1	151,998.3						
3	Бодь электроник компанитай байгуулсан 2024 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн Г/85 дугаар Компьютер худалдан авах гэрээний 2.6-д заасан төлбөр төлөх нөхцлийг зөрчиж, төлбөрийг бүрэн төлж, 3 сарын дараа хөрөнгийг хүлээн авч хувийн хэвшлийг дэмжсэн байна	1	189,454.5					1	189,454.5				
4	Төслийн санхүүжилтээр нийлүүлэгдсэн эм оношлуур, бараа материалыг эрүүл мэндийн байгууллагуудад хувиарлаж, зарлагдсаны дараа ЭМЯ-ний төрийн нарийн бичгийн даргын бараа материал хувиарласан тушаал шийдвэрийг нөхөн гаргуулж, баримтыг бүрдүүлж байгаа нь төслийн хөрөнгө үр ашиггүй зарцуулагдах эрсдэлтэй байна.	1	17,589.1					1	17,589.1				
	Дүн	4	<b>362,741.9</b>			1	151,998.3	3	210,743.6				



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 16 өдөр

Дугаар 558/A0150185

Улаанбаатар хот

САГ-2026/86/НА-СТА-ТХМ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Эрүүл мэндийн яам, Глобаль сангийн дэмжлэгтэй ДОХ, Сүрьеэгийн төслийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Үндсэн хөрөнгийн дансанд бүртгэлтэй 151,998,257.00 /нэг зуун тавин нэгэн сая есөн зуун ерэн найман мянга хоёр зуун тавин долоон/ төгрөгийн өртөг бүхий суудлын автомашиныг ашиглалтын түрээсийн гэрээгүй, шийдвэргүй, дээд шатны байгууллагад ашиглуулж байна.


Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1-т "Төрийн өмчийн эд хөрөнгийг эрх бүхий байгууллагын шийдвэрээр төр, хувийн хэвшлийн түншлэлийн болон түрээсийн гэрээгээр, мөн хуулиар зөвшөөрсөн бол үнэ төлбөргүйгээр бусдад эзэмшүүлж, ашиглуулж болно" гэж заасантай нийцээгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1.3-т "өмч, хөрөнгийг бусдад зүй бусаар ашиглуулсан" гэсэн заалтын тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Үндсэн хөрөнгийн дансанд бүртгэлтэй суудлын автомашиныг ТӨБЗГ-ын шийдвэргүй, ашиглалтын түрээсийн гэрээгүй дээд шатны байгууллагад ашиглуулж байгаа зөрчлийг таслан зогсоох, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх.
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Эрүүл мэндийн яам, Глобаль сангийн дэмжлэгтэй ДОХ, Сүрьеэгийн төслийн зохицуулагчийн үүрэг гүйцэтгэгч /Б.Гансүх/, төслийн санхүүгийн мэргэжилтэн /Б.Шинэтуяа/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
АУДИТЫН МЕНЕЖЕР  
ГЭРЭЛТ ХӨХИЙН ТЭНЦВЭР АУДИТ  
ХХК-ИЙН ЗАХИРАЛ



Ц.НАРАНЧИМЭГ  
В.ӨРДЭНЭЦОГТ

Д.БААТАРСАЙХАН